



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/36

Хөхбүрд

┌ Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн ┐
бүртгэл үзлэг, тооллогыг зохион байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.10, “Автотээврийн тухай хууль” –ийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Зам, тээврийн хөгжлийн яамны сайд, Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/57/48 хамтарсан тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Овоо суманд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийг журмын дагуу үзлэг, тооллогод бүрэн хамруулах арга хэмжээг сумын хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 20-ны хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Г.Ганцоож (Засаг даргын орлогч)

Гишүүд:С.Дашбалбар (Хэсгийн төлөөлөгч)

А.Тогтохбаяр (Цагдаа)

Д.Эрдэнэбулган (Татвар хураагч)

Т.Цэцэгсайхан(Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

3.Тооллогын арга хэмжээг зохион байгуулсан ажлын үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 22-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

642301037